IV уе:	(цуусны зргэлтийн алдагдал A, B, C, D)

Эмнэл зүй

I уе шат: хөнгөн үе

Зовниур :

- хуурай эсвэл бага зэргийн цэргэй ханиах

- хаяга амьсгал давчдах
- бисийн хүчиний ачааллын үед амьсгаадах шинж илэрнэ.

Бодит үзлэг: Шинж тэмдэг бага илэрнэ

- амьсгалын дээд замын салст бурхул, хамрсан хөндий, хамар залгиур, төвөнхий хамарсан хатингаршилт үрэвэл илэрнэ
- тогшилтын дуу хэвийн, чаннахад амьсгал ширүүн, бага зэргийн хурай хэржигнуур нь ханиахад алга болно.

Гадаад амьстальын үйл ажиллагданы үзүүлэлтүүд хэвийн боловч зарим үзүүлэлтүүд АГДХ.

ХАГЭ, багасч болно.

Садрэл нь жилд 1-2 удаа, 7-10 хоног үргэлилээ.



// үе шалт: идэвхтэй үрэвслийн үе

Зөвнур:

- бисийн байдал сул
- хөлрех
- бисийн хүчиний ачааллын үед амьсгаадах
- оройд субфебриль халуурах
- ханиалга ихэнэ, салсархаг идээц цэргийн ханиана, зарим үед цэр ховхрохдоо муу, боон хэлбэртэй гарна.

Бодит үзлэг:

- Чаннахад амьсгал гаргалт удааширна, хурай хэржигнуур, доод хэсгээр нойтон хэржигнуур сонсодно.

Лабораторийн шинжилгээнд:

Цусны дэлгэрэнгүй шинжилгээ:

- нейтрофилийн хазайлт
- УЭТХ хурдсах

Биохимиийн шинжилгээ:

- фибриноген, С-уураг, гаптоглобин ихэнэ, уургийн фракцийн харьцаа, хучиллэг шүүлтэг фосфатаза вөрчлөгдөнө.

Гадаад амьсгалын үйл ажиллагданы үзүүлэлтүүд АГДХ, ХАГЭ, багасна, эмфизем хавсарсан үед УХАБ 85% - авс багасна. Цусны хүчинторвичийн ханалт 93-90% болж буурна.

Зүрхний цахилгаан бичлэгт:

- Зүрхний баруун талын ачааллын шинж тэмдгүүд.
 - цахилгаан тэнхлэг баруун тийш хазайна
 - р-рийтнаle II, III холболтонд гарна
 - щилжилтийн бүс баруун тийш шилжина
 - V₁, V₂ д гүнагийн S шуд гарна.

Рентген шинжилгээнд

уушини зураглалд:

- уушигны доод талбайд зураглал ихэнэ.
- торлог халбэрээр дурсээ алдана (пневмосклерозын шинж тэмдэг)
- утийн ялгарал алдагдаж, нэмэлт сүүдэр үүснэ.

- уушги талзгэлт тодорхойлогдоно (тэр хэсэгт уушгини тунгалаг чанар ихэснэ).

III уе шамт: хүнд үе

Зониур:

- байнга цөртэй ханиах
- тайван үед амьсгаадах
- цээжээр вадех
- амьсгалахад хундралтэй
- халдвэр хавсарвал халуурах, бие сулрах, идээтэй цэр, хөлпрөх шинжүүд гарна.

Бодит үзлэг:

- захын хөхрөлт
- амьсгалд туслах бүлчингүүд оролцох
- цээжний ханхорцийн омнод- арын хэмжээ оргасех
- тогшилтоор уушгини зайдмийн ходолгоон хязгаарлагдах, эмфиземтэй хэсэгт хайрлаган чимэээтэй
- чанахад амьсгал супарсан, хуурай харжигнуур, доод хэсгээр нойтон харжигнууртой.

Гадаад амьсгалын үйл ажиллагааны үзүүлэлтүүд эрс буурна. Цусны хүчилтөрөгчийн ханалт 85-80% болж буурна.

Цусны дэлгэрэнгүй шинжилгээ:

- эритроцитоз, неитрофилийн зуунд хазайлт

Рентген шинжилгээнд:

- Уушгини эмфизем
- Пневмосклероз
- Гилтанийн наалдац тодорхойлогдоно.

Бронхоскопид:

- Гуурсан хоолойн салст бурхуулуйн зорчилот, жаюог, дунд бронхууд салсаар бөглерсон гуурсан хоолойн ханын хөдөлгөөн алдагдсан байна.

¹АГДХ- Амьсгал гаргалтын дээд хурд

²ХАГЭ- хүчилсон амьсгал гаргалтын эхний 1 секундад гарах агаарын эзлэхүүн

³УЭТХ- улан зэйн тухай хурд

⁴УХАБ- уушгини хүчилсон амьдралын багтаамж

Оношлогоо

Анамнез:

- ажил, мэргэжлийн онцлог
- ажлын цаг
- тухайн нахцэвд тасралтгүй ажилласан хугацаа
- хөдөлмөрийн нохцол
- тоос тоосонцрын бүтэн найрлагыг тодруулахад түлхэц болохуйц мөдээллийг багтаана.
- өвчиний эхлэл, үргэлжилсэн хугацаа, суурь өвчиний талаар сайтар лавлаж асууна.
- ажлын байрны эруул ахуйн шинжилгээний дүтнэлт

Бодит үзлэг

Шинжилгээ	Лабораторийн шинжилгээ
	- цусны дэлгэрэнгүй шинжилгээ - шээний ерөнхий шинжилгээ - царний шинжилгээ - биохимийн шинжилгээ
	Рентген шинжилгээ
	Гадаад амьсгалын үйл ажиллагааг спирометрээр тодорхойлох Зурхний цахилгаан бичлэг Шаардлагатай гэж узвэл номолт шинжилгээнүүд; HRCT (өндөр ялгаралт компьютерт томографи), бронхоскопи хийнэ

Эмчилгээ

Nr	Эмчилгээний төрлүүд
I.	Дэглэм: <ul style="list-style-type: none">• Ажлын нахцэлийг өөрчлөх, хамгаалалтын хувцас, хошуувчтай ажиллаж хэвшигх• Илчлаг сайтай хоол, уураг, витаминаар баялаг хүнс хэрэглэх• Биеэ чийрэлжүүлах• Амьсгалын дасгал тогтолц хийх• Ханиад томуунаас сэргийлэх
II.	Гуурсан хоолойн дамжуулах үйл ажиллагааг сайжруулах <ul style="list-style-type: none">• цэр шингэлэх, ховхлох эмүүд
III.	Үрээслийн эсрэг эмчилгээ
IV.	Цусны хийн бутцийг засах: <ul style="list-style-type: none">• хувцалтерөгч эмчилгээ
V.	Биеийн ерөнхий байдлыг сайжруулах эмчилгээ
VI.	Өвчиний явц хөнгөн үед Цагаан мөгөөрсөн хоолой, гуурсан хоолойн салст бүркүүлийн цусан хангамжийг сайжруулах зорилгоор: <ul style="list-style-type: none">• цээжийг хэт яваан түяагаар (УФО) 5-10 удаа шарлагана хийх Өвчиний явц хүнд үед<ol style="list-style-type: none">1. диатерми өдөр бүр хийх2. соллюкс 20-30 минутаар өдөрт 1-2 удаа хэрэглэх нь үр дүнтэй

Урьдчилан сэргийлэлт

Эх үүсгэвэрт чиглэсэн арга хэмжээ :

Тоос үүсэлтийг баласаах, тоосгүй ажлын орчин бурдүүлэх:

- Услалт
- Чийгшүүлэлт
- Усан мананцар бий болгох
- Агааржуулалтыг техник, тоног техноломохийг сайжруулах

Хувь хүнд чиглэсэн арга:

- Хувийн хамгаалалтын хэрэгслэлүүдээр ажиллагсдыг хангах, хэрэглэж хавшигулах.
- Ажиллагсдын биеийн эсаргууллийг сайжруулах. (витаминжуулалт, сувилалд амруулах)

Ажиллагсдын эмнэлгийн урьдчилсан ба хугацаат үзлэгт зааврын дагуу хамруулна.

Хөдөлмөр зохицуулалт

- Өвчиний үед ажлын хортой нэлэөллөөс чалоөлж, ажлын нөхцөл солино.
- Дараагийн үеүүдэд эмнэл зүйн байдлаас хамааран, хөдөлмөрийн чадвар алдартын хувь, хэмжээ, хугацааг тогтоно.

1.6. МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН БАГТРАА

Тодорхойлолт

Гуурсан хоолойн мэдрэг байдал верчилгэдэж, эмгэг верчилт нь хөөнгө эс болон зозинофил эсийн түвшинд явагддаг, багтраат байдал, амьсгал боогдох, цээж давчдах байдлаар илэрдэг амьсгалын замын архаг урэсэлт өвчинийг багтраа гэнэ. Үйлдвэрлэлийн орчны хөийн бус хүчин зүйлс шинээр багтраа үүсгэх буюу урьдах багтраа өвчинийг сэдрээхийг мэргэжлийн шалтгаантай багтраа гэнэ.

Нөлөөлөх хүчин зүйлс, мэргэжил

Үйлдвэрлэл	Ажил, мэргэжил	Нөлөөлөх хүчин зүйлс
------------	----------------	----------------------

<ul style="list-style-type: none"> ХАА-н салбарууд Мод боловсруулах Химийн үйлдвэр Лаборатори Оёдол, нэхмалийн цехүүд Хүчиний үйлдвэрүүд Эм био бэлдмэлийн үйлдвэр Гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл Архив Амьтадтай харьцдаг ажлууд 	<ul style="list-style-type: none"> Агрономч Шудэнзний үйлдвэрт толгойн бодис найруулагч Химич, лаборант Будагчин, нэхмэлчин, ялгач, сэгсөрэх машин баригч, хялгас ялгах цехийн машин баригч, чанар шалгач, нормчин Эм найруулагч, шир угзагч, ариутгач, эм зүйч Архивчид <p>Малын эмч, амьттан малингч, туслах ажилтан, биобэлдмэлчин.</p>	<p>Органик бус аллерген:</p> <ul style="list-style-type: none"> тервел бурийн темор никель хром цагаан алт кобальт канифоль формалин эпихлоригидрийт битум нийлаг полимерууд нитро будгууд <p>Органик аллерген: ургамлын гаралтай тоосны тервел бурийн хэлбэр.</p> <ul style="list-style-type: none"> гурил амуу тария ульзан буудай хөх тария овьбос нарс, хүш, хүс, гацуур г.м модны тоосондор хөвөн маалинга тамхи эфирийн тос г.м <p>Антибиотикууд Нойрсуулах, мэдээ алдуулах замууд Хүнцэл болон мянган усны бэлдмэлүүд, иодын нэгдлүүд. Амьтны ус, ноос, хорхой шавьжны ялгаруулсан тоос.</p>
---	--	--

Ангилал, эмнэл зүй

Явцаар нь:

Завсарлагаатай хөнгөн зэрэг: 7 хоногт нэгээс цеен, шинж тэмдэг багатай садэрно. Садрэл нь үйлдвэрлэлийг аллергентэй харьцахгүй уед болон гуурсан хоолой тэлэх змийн бэлдмэлгүй амархан хэвийн болно. Намжмал уед уушгины үйл ажиллагааны өөрчлөлтгүй байна.
Хөнгөн тогтолци: Өвчний садрэл хөнгөн боловч явц удаашрана. Гадаад амьсгалын үйл ажиллагааны үзүүлэлтүүд хоногт 20-30% хэлбэлзэнэ. Садарсан уедээ эмчилгээнд хялбар засарна

Дунд зэрэг: Үе үе садэрнэ. Намжмал уед ханиалгах, амьсгаадах шинжүүд, чанхаад уүшгинд хуурай хэржигнуур сонсогдоно. Уушгины эмфиземийн шинжүүд илэрнэ. Гадаад амьсгалын үйл ажиллагааны үзүүлэлтүүд тогтворгүй, садрэлийн уед эмчилгээнд хялбар засрахгүй. Олон аллергенүүдэд харшилтай байна.

Хүнд зэрэг: Садрэл нь ойрхон, удван ургалжилна. Гадаад амьсгалын үйл ажиллагааны үзүүлэлтүүдийн хэлбэлзэл 30%-с илүү байна. Багтраат байдалд үе үе орно, эмчилгээнд сайн

засрахгүй, уушгины эмфизем, уушгин зурхний хүндэрэл илэрнэ.

- Багтрааны үед бүх харшлын өвчний нийтлэг эмнэл зүйн шинжүүд гарна.
- Багтрааны дурын хэлбэрийн эмнэл зүйн салшгүй гол шинж бол амьсгал гаргахад саадтай бачуурал гэнэт хөдлийн нийтлэг шинж байдал.

Хүндрэлүүд

1. Уушгины үрэвслэл
2. Гуурсан хоолой тэлэх өвчин
3. Уушгины бутлаа
4. Ателектаз

Оношлогоо

Анамнез: <ul style="list-style-type: none">Хүрц үнэр, бусад садзах хүчин зүйл (орчны агаарын хэм опцом верчлэгдэх, хүйтэн агаар, сэтгэл санааны ачаалал) нь өвчинийг гэнэт хөдөлгөнө.Багтраа сэдрээгүй үед "ялангуяа шено, еглөө үүрээр исгэрсан амьсгалтай" байх ихэвчлэн амьсгалын дээд замын дагалдах өвчтэй холбоотой байдал.	Зовиур: <ul style="list-style-type: none">амьсгал боогдох, цээж давчдах, истирч шууих, бачуурах, өтгөн, хөвхрохгүй цартай ханизнаа Амьсгал гаргахад саадтай бачуурах шинж гарна.Бачуурах шинж нь ихэвчлэн зайнласон сонсогдох исгэрсан хэрэгжүүртэй хамт илэрна.Багтрааны үед "исгэрсан амьсгал" нь амьсгалахад гэнэт саадтай болох үед, веөөр-хэлбэл бачуурал хөдлихэд илэрдэг.
Бодит үзлэг: <ol style="list-style-type: none">1. Өвчтөний гадаад бандал:<ul style="list-style-type: none">Садзийн үед өвчтөн албадмал байрлалтайөвчтөн ямар нэг юмыг хоёр гарцаараа тулж суусан, эсвэл зогссон байдалбачууралт тавигдахад ханиалгаж, бага зэргийн хэмжээтэй салсархаг, салсархаг идэээт цэр гарна.Арьс, хумс, уруул хөхөнлөрЦээжийн хэнхэрцэг өргөссөн байна.	<ol style="list-style-type: none">2. Тогшиход:<ul style="list-style-type: none">уушгины зайдын хөдөлгөөн хвагаарлагдсанхайрцган чимээтэй3. Чагнахад:<ul style="list-style-type: none">амьсгал звах, гаргахад исгэрсан хуурай хэрэгжүүртэйхүнд тохиолдолд амьсгал сонсогдохгүй.

1. Шинж тэмдгийн
 - Ажлын орчинд хий, утваа, уур тоос үйлчлэхад эмнэл зүйн шинжүүд илрэх
 - Амралтын адрууд, эзлжийн амралтын үеэр шинж тэмдгүүд арилж, биеийн бойдал сайжрах
 - Ханиах, истирч амьсгалах, амьсгалдах шинжүүд аяндаа зүгээр болох
 - Эргэх шинж чанартай бөглөрөл дунд, жижиг эрэмбийн гуурсан хоолойг давамгайлан хамарсан байх.

2. Багажийн оношлогоо

А. Пикфлюметрийн хоногийн хяналтаар:

- гуурсан холойн дамжилтын хэлбэлзэл 20%, түүнээс их байх

Б. Гадаад амыгдлын үйл ажиллагааны шинжилгээнд:

- АГХДХ¹-ыг ажил болон гэрт харьцуулж хэмжинэ

3. Цусны шинжилгээнд

- Захын цусанд бага зэргийн гиперрезинофили (20% хуртэл)

- Цусан дахь IgE хэмжээ илэрхий ихсэх

4. Цэрний шинжилгээнд

эозинофил илрэх

5. Харшлын сорилт:

Экзоаллергентэй арьс хаттаж харшлын сорилт зөврөг байх

АГХДХ¹-амыгдл гаргалтын хурдны дээзд хэмжээ

Эмчилгээ

I.	<p><i>Гистаминий эсрэг бэлдмэл</i></p> <p>Уушгини бус харшлын вичинтай хавсарсан үед</p> <ul style="list-style-type: none">• хөрдүгээр үеийн• гуравдугаар үеийн <p>Харшлын урвалын хурц үед</p> <ul style="list-style-type: none">• намдаах зорилгоор антигистамины нэгдүгээр үеийн эмийг тариагавр хэрэглэнэ
II.	<p><i>Эсийн мембранныг бэхжүүлэгч эм</i></p> <p>Хоногт 4 удав урьдчилан сэргийлах зорилгоор хэрэглэнэ. Эмчилгээний үр дун 10-14 хоногийн дараа илэрхэг эхэнэ. Курс эмчилгээг 3-4 сар ба түүнээс урт хутацаагавр хийнэ.</p> <p><i>Хавсарсан бэлдмэл:</i></p>
III.	<p><i>β_2-агонист</i></p> <p>Гуурсан холойн бөглөрлийг арилгах, бачуурал ходлохийг тавиулах зорилгоор болино үйлчилгээтэй эмийг (зайлшгүй шаардлагагаар)</p>
IV.	<p><i>Антихолинерг бүлгийн бэлдмэл.</i></p> <p>Гуурсан холой тэлэх үйлдэл нь β_2-агонисттай харьцуулахад хүнтэй ч, үйлчилгээ нь ажлын экзандыг</p> <ul style="list-style-type: none">• М-холинергийн бэлдмэл
V.	<p><i>Антилеукотриены бэлдмэл</i></p> <p>закфирлугааст</p>
VI.	<p><i>Муколитик эм</i></p> <p>Багтраа евчин гуурсан холойн архаг үрэвсэлтэй хавсарсан үед ихзачлан хэрэглэнэ</p>

VII.	Глюокортикоид
VIII.	Цацлагын глюокортикоид

Багтраанаас сэргийлэх (намжилтын усийн) эмчилгээ

Үе шат	Удаан хугацааны сэргийлэх эмчилгээ
4-р шат Байнгын хүнд зэрэг	Үрэвслийн эсрэг зорилгоор кортикоид ондor тунгаар 800-2000 мг цацлагваар Удаан үйлдэлтэй β_2 -адреномиметик шахмалазар, ингалициар Удаан үйлдэлтэй теофиллин кортикоид шахмал /тунг багасгах/
3-р шат Байнгын хүндсээр зэрэг	Үрэвслийн эсрэг кортикоид дундаж тунгаар (800-200 мг-аас бага). Удаан үйлдэлтэй гуурсан хоолой тэлэх эмууд. (ялангуяа шенийн багтрааас сорлийлх) зайлшгүй тохиолдолд 2 эм хосогж хэрэглэнз.
2-р шат Байнгын хонаар зэрэг	Үрэвслийн эсрэг кортикоид дундаж тунгаар 200-500 мг
1-р шат Завсарлаваа тайв хөмгийн зэрэг	Өдөр бүр эмчилгээ шаврдлагагүй, болино үйлдэлтэй гуурсан хоолой тэлэх эм - ингалицийн β_2 -агонист, интал анааплын өмнө, аллергены хавьтапын үед

Насанд хурэгсэд ба 5-аас дээш насны хүүхдийн хяналтанд сууринсан эмчилгээний зарчмын

Хяналтын түвшин	Эмчилгээний явц			
Хянагдах боломжтой	Хянагдах боломжтой хамгийн дээд түвшинт тогтоож барих			
Гүйцэд хянагдах боломжгүй	Хянагдах боломжтой болтолж шатлаш ашиглаж			
Хянагдах боломжгүй	Хянагдах боломжтой болтолж шатлаш ашиглаж			
Сэдрэл	Сэдрэлийн эмчилгээ			
↑ ↓ Эмчилгээний алхам (үе шат) ↓ ↑				
Алхам 1	Алхам 2	Алхам 3	Алхам 4	Алхам 5

Гадаад орчны хяналт Өвчний сургалт				
Шаардлагатай бол болино үйлчилгээтэй B_2 - агонист	Шаардлагатай уед болино үйлчилгээтэй B_2 -агонист			
Ажиглалт ^{**}	Нагийг сонгох	Нагийг сонгох	Алхам 3-ын эмчилгээнэгийг звэвл хэд хэдийг сонгох	Алхам 4-ын эмчилгээ+ хөөтанг сонгох
	Цацлагын КС Бага тунгаар	Цацлагын КС бага тунтуудаан үйлдэлтэй B_2 - агонист	Цацлагын КС дунд болов ондер тунтуудаан үйлдэлтэй B_2 -агонист	КС уухаар (бага тун)
	Лейкотриены эрэг бэлдмэл	Цацлагын КС- дунд болон ондер тун	Лейкотриены эсрэг бэлдмэл	IgE-ын эсрэг эмчилгээ
	Цацлагын КС + Лейкотриены эрэг бэлдмэл	Цацлагын КС + Лейкотриены эрэг бэлдмэл	Удаан үйлчилгээтэй теофиллин	
	Цацлагын КС + Удаван үйлчилгээтэй теофиллин			

*Цацлагын КС-цацлагын кортикостероид

**Рецепторын антагонист зөвлөл синтетик ингибитор

** -Сүүдэртүүлсэн хүснэгтэд хянагдаж буй ба граваны эмчилгээг харуулсан.

Эмийн бус эмчилгээ

I.	Зүү эмчилгээ, цэгэн иллэг
II.	Эсэргүүцэлтэй ба амыгслал түгжсэн амыгслалын дасгал
III.	Эмчилгээний хоол
IV.	Рашаан сувилал (Ест. Шаргалжуут)
V.	Нар, ус, агаараар чийрэгжүүлах

Урьдчилан сэргийлэлт

Эх уусгэвэрт чиглэсэн арга хэмжээ:

Тоос уусалтийг багасгах, тоосгүй ажлын орчин бурдуутах, химийн бодисын хяналтыг сайжруулах.

- Услалт
- Чийгшүүлэлт
- Усан мананцар бий болгох
- Агааржуулалтыг техник, тоног төхөөрөмжийг сайжруулах, хангах
- Химийн бодисын бит үүмжлэл, хадгалалтыг сайжруулах

Хувь хунд чиглэсэн арга хэмжээ:

- Хувийн хамгаалалтын хэрэгслэлүүдээр ажиллагсдыг хангах, хэрэглэж хэвшүүлах.
- Ажиллагсдын биеийн эсэргүүцлийг сайжруулах (витаминыкуулалт, сувиланд амруулах).

Ажиллагсдыг змэнглийн урьдчилсан ба хугацаат үзлэгт зааврын дагуу хамруулна.

◆ **Хөдөлмөр зохицуулалт**

- Хөнгөн явцтай үед ажил, мэргэжлийг солино.
- Өвчний явцас шалтгаалан хөдөлмөрийн чадвар алдартын хувь тогтоона.

1.7. МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН АМЬСГАЛЫН ДЭЭД ЗАМЫН ӨВЧНҮҮД

Үйлдвэрлэлийн явц, ажлын байрнаас үссэн орчны хортой, аюултай хүчин зүйлс нь амьсгалын замаар амьсгалын дээд замын салстад нөлөөлөн үссэн үзвэслийг хэлнэ.

- Химийн хүчин зүйл-химийн бодисуудын ууршилт, тоос, хий, уур, мананцар
- Физикийн хүчин зүйл-ионжуулагч түка, агаарын температур

- Биологийн хүчин зүйл-бичил биетэн, вирус, эзэл биетэн, шимэгч

Үйлдвэрлэлийн салбар, ажил мэргэжил, нөлөөлөх хүчин зүйл:

Ажлын байр	Мэргэжил	Нөлөөлөх хүчин зүйл
Химийн салбар хөөснөнцрийн үйлдвэр, нарийн боов, фермийн аж ахуй, модны ажил, урамгын тоосны нөлөөлөлтэй ажил мэргэжлүүд, нахмэлийн будаг, эмнэлгийн байгууллага, эмийн үйлдвэр, хромын үйлдвэр, металлын үйлдвэр, будгийн үйлдвэр, кунцал опборолт ба боловсруулах үйлдвэр, төмөрлөг ба зас хайлтуулах үйлдвэр, пестицид, гербицид үйлдвэрлэх, хэрэглэх, шилний үйлдвэр, цементийн үйлдвэр, жоншны уурхай, хэвлэх үйлдвэр, савхи ба нэхий боловсруулах үйлдвэр, ил опборгох уурхай, бутлуур тээрэм	Эмнэлгийн ажилтнууд - ариутгатч, эм зүйч, янз бурийн салбарын будачин, лаборант химич, гагнуурчин, агрономч, мухсан, уччин, дизельчин, арьс алдагч, электролизийн ажилчид, химийн бодис болон цемент, жонш, гурил зэрэг нунтаг бодис, нунтаг бүтээгдэхүүн савлагч г.м. мэргэжлийн хүмүүс илүү өртөмхий байдаг	<ul style="list-style-type: none"> Ажлын байрны температур хэт ондор байх Хортой туяа, химийн бодисны нөлөөнд удаан хугацаагаар ажиллах Зөвшөөрөгдөх хэмжээнээс бага гаралтуулжтай орчинд удаан хугацаагаар ажиллах Ажлын байрны хадалмаврийн аюулгүй байдал, хангамж муу байх Бичил биетэн, вирус, эзэл биетэн, шимэгчийн шалтгаант гэмтлүүд г.м

Ангилал

Явацаар нь	• Хурц
	• Архаг
Хэлбэрээр нь	Архаг <ul style="list-style-type: none"> Улаих Хеенгетөх Хатингаршлын урьдал Хатингарших Ургацаг тест
Хүндрэлээр нь	• Хамрын таславч цоорох <ul style="list-style-type: none"> Дууны хөвчийн саажилт Хавдар
Байрлалаар нь	• Хамрын үрэвслэл <ul style="list-style-type: none"> Залгиурын үрэвслэл Төөнхийн үрэвслэл Хамар залгиурын үрэвслэл Хамар дайврын үрэвслэл Залгиур төөнхийн үрэвслэл
Үе шатаар нь	• I-хульсур /вазомоторный/ <ul style="list-style-type: none"> II-харшлын III-багтраны өмнөх үе

Эмнэл зүй

Зониур	<p>Хамрын үрэвсал</p> <ul style="list-style-type: none"> хамар битуурх найгаалгах хамраас ялгадас гоожих үнэр мэдрэх чадвар алдагдах дүү гүнших <p>Залгиурын үрэвсэл</p> <ul style="list-style-type: none"> хоолой евдех хоолой хатаж, хуурайших дүү паргих <p>Төөнхийн үрэвсэл</p> <ul style="list-style-type: none"> хоолой сөөх хоолой хуурайших, сэрэгнэх дүү амархан цуцах дүү гарахад зэгүй оргино
Бодит үзлэг	<ul style="list-style-type: none"> Харах Тэмтрэх Риноскопи-хамрын хөндийн омнод тольдолт Эпифарингоскопи-хамрын хөндийн арын тольдолт Мезофарингоскопи-залгиурын үзлэг Гипофарингоскопи-төөнхийн шууд бус тольдолт Үнэрлэх үйл ажиллагааг шалгах (үнэрлэх үйл ажиллагаа буурна) Рентген шинжилгээ болон MRI, СТ Эндоскопийн шинжилгээ Биопсийн шинжилгээ Нэмэлт шинжилгээ Электротермометр /хамрын салстын тэмператур хэмжих 31,2-34,4 C° Риноцитологи /хамрын салстын шуурэнтээс зозинофил эс тоолох (+++) Ольфактометр - үнэрлэх үйл ажиллагааг шинжилэх Намираа хучуур эсийн зөвөөрлөх үйл ажиллагааг шинжилэх (норм- 16-20 минут) Хамрын салстын устремчайн ионы хувийг шинжилэх (лакмусын цвасаар шинжилж үзэх) Өөврмөц шинжилгээ -харшлын сорилт (арысан дээрх, арьсан доторх хамрын хөндийн сорилт)

Хувьсуур үе	<p>Хэлбэрүүд</p> <ul style="list-style-type: none"> Улайх Хөөнгөвхөх Хатингаршлын үрьдал 	<p>Бодит үзлэгээр илрэх шинж тэмдэг</p> <ul style="list-style-type: none"> Улайх хэлбэр үед салст бурхавчийн нэвчимхий чанар ихсэн шуурэл ихсэн
-------------	--	---

Харшлын ўс	<ul style="list-style-type: none"> • Хөөнгөтөх • Хатингаршилын урьдал • Хатингарших • Ургацаг тэст 	<ul style="list-style-type: none"> - Хөөнгөтөх хэлбэр үед салст бурхзоч хөөнгөтөн, хөх түватай болж хамрын хөндийн амьстал саадтай болно. - Хатиргаршилын урьдал хэлбэр үед хамар хоолой хуурайшиг найтаалгах, сарвэгнах - Хатингарших хэлбэр үед салст бурхзоч гялбар цайвар ягаан өнгөтэй болж дахилтат хэлбэрийн хуурай ханиалгах
Багтрааны өмнөх ўс	<ul style="list-style-type: none"> • Хөөнгөтөх • Хатингаршилын урьдал • Хатингарших • Ургацаг тэст 	<ul style="list-style-type: none"> - Ургацаг тэст хэлбэр үед салст бурхзоччид ургацаг тэст верниелт илрэн, байнга найтаалгах, камар биттуурч илгадас ихсэн, дахилтат хэлбэрийн хуурай ханиалгах, цээж хүнд оргих - Багтрааны өмнөх үед амьсгавалт илэрнэ

Оношлогоо

- Зониур
- Анамнез /ажилласан жил, мэргжлийн онцлог, ажлын байрны сорог налоопог/
- Эрүүл ахуйн хэмжилтийн дүгнэлт
- Бодит узлэг
- Шинжилгээ

Яланг оношлогоо

- Бусад шалтгаант амьсталин дээд замын үрэвсэл

Эмчилгээ

Ерөнхий биеийн эсэргүүцэл сэвжруулах эмчилгээ - аминдэм уулгах, биологийн наимээг бүтээгдэхүүн хэрэглэх

Хэт мэдрэгшилт байдлыг бууруулах эмчилгээ, Физик эмчилгээ, Раашан суурин

Хэсэг газрын эмчилгээ:

	Улаих хэлбэр	Хөөнгөт хэлбэр	Хатингарших хэлбэр
Хамрын үрэвсэл	<ul style="list-style-type: none"> - Хамарт зм дусвах - Хамрын хөндийг утаах 	<ul style="list-style-type: none"> - Самалдагт тарив хийх - Цахилгаан - Төөнүүрээр түпэх - Самалдаг тайрах мэс засал 	<ul style="list-style-type: none"> - Тосон эмчилгээ (олкосерин тос) - Доод самалдагт салст суулгах

Залгиурын үрэвсэл	<ul style="list-style-type: none"> - Утлага - Аспептик уусмалаар арчих - Аспептик уусмалаар холой зайлх 	<ul style="list-style-type: none"> - Нитрат монголийн уусмалаар арчих - Түлэх - Хөвлөвх - Түүх - Хоолой зайлх 	<ul style="list-style-type: none"> - Люголиор арчих - Ментолоор арчих - Тосон эмчилгээ - Раашан эмчилгээ - Хоолой зайлх
Төвөнхийн үрэвсэл	<ul style="list-style-type: none"> - Утлага - Гидрокортизонны суспензээр арчих 	<ul style="list-style-type: none"> - Утлага - Аргентум нитратаар арчих 	<ul style="list-style-type: none"> - Утлага - Люголиор арчих - Ментолоор арчих - Тосон эмчилгээ - Раашан эмчилгээ

Урьдчилан сэргийлэлт

- Улирал тутамд эрүүл ахуйн хэмжилтүүдийг хийж байх
- Ажлын орчинт байнга чийгтэй байлгах (услах)
- Хувийн хамгаалах хэрэгсэл тогтмол хэрэглэх (хошуулч)
- Эмнэлгийн бурдмал болон зориудын урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамрагдах
- Бие махбодыг чийрэгжүүлэх, зруулжүүлэх (амьсгалын дээд замын архаг халдвартыг эмчилэн эрүүлжүүлэх) Үүнд: Архаг гүйлсэн бүлчирхайн үрэвсэл, архаг хамрын үрэвсэл, хамрын дайврын үрэвсэл
- Илэрхий хамрын таславчийн муруйлтаас хамрын амьсгал саадтай тохиондолд; мөс засал эмчилгээг хийна.

Хөдөлмөр зохицуулалт

Өвчний илрэлийн зарег, өвчний хүндэрэл, хөдөлмөрийн эрүүл ахуйн нахцал, тасралтгүй ажилласан жил, маргажтлийг харгалзан үзэж, ажлын байрнаас түр болон бүр мөсөн чөлөөлж, хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг зохих заалтын дагуу тогтоонно.

2.1. МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН НУРУУ БҮСЭЛХИЙН ЯЗГУУРЫН ӨВДӨЛТИЙН ХАМШИНЖ

Тодорхойлолт

Хедэлмэрлэх явцад зориудын байнгын хүч шаардсан, түргэн эрчимтэй эскуп нэг хэзийн давтагдсан хедэлгэентэй ажлын нахцол нь биеийн албадмал байрлал, тааламжгүй бичил цаг уур, доргионы нөлөөлөлтэй хавсрэн нурууны нутамалын дегенератив өөрчлөлтийн улмаас нуруу, бүсэлхийн-ууцны хүрээнд үүсэх өвчлөлийг мэргэжлээс шалтгаалсан нуруу бүсэлхийн нэгүүр мэдрүүгийн өвдөлтийн хамшинж гано.

Нөлөөлөх хүчин зүйл, мэргэжил

Үйлдвэрлэлийн салбар	Ажил, мэргэжил	Нөлөөлөх хүчин зүйл
<ul style="list-style-type: none">• Барилга• Уул уурхай• Зам тээвэр• Хүнд үйлдвэр• Хөнгөн үйлдвэр• Хөдөө аж ахуй• Засвар механик	<ul style="list-style-type: none">• Уул уурхайн үйлдвэрийн ажилчид• Хүнд машин механизмын операторууд• Хүнд машин механизмын засварчид• Дархан, мужаан• Будагчин, онголгоч, зүлгэгч Ачигч• Галч• Чулуучин• Сийлбэрчин• Цоопборчин• Хэвчин• Цувигч• Темерчин• Угаач• Гагнуурчин• Токарьчин	<ul style="list-style-type: none">• Гар ажиллагаатай биеийн хүч шаардсан хагас автоматиксан буюу мөхөнжоулсан ажил• Албадмал ба даачуу байрлалтай ажлын байр• Тэнцвэргүй давтамжтай, нэг хэзийн үйлдэлтэй ажил• Дааралтат ба үрэлтэй багаж төхөөрөмжтэй харьцааг• Бичил цаг уурын чийг, капуун, хүйтний нөлөөлөл• Доргион• Химиин бодис• Биомеханикийн хувийн онцлог чанар• Бусад биеийн хувийн эзт ачаалал

Аншилал

I. Нурууны гарвалт нутасны язгуурын өвдөлтийн хамшинис:

1. Бүсэлхийн-ууцны язгуурын өвдөлтийн хамшинж
 - Бүсэлхийн өвдөлт (люмбаго, ломбалти)
 - Бүсэлхийн-суудлын өвдөлт (люмбоициалги)
 - Лийр хэлбэрт булчингийн хамшинж
2. Бүсэлхийн-ууцны язгуурын дарагдлын хамшинж (радикулопати)
 - L4 ёзоорын хамшинж
 - L5 ёзоорын хамшинж
 - S1 ёзоорын хамшинж
 - Адуун сүүлний хамшинж

II. Хүзүү-сээрийн язгуурын өвдөлтийн хамшинж:

1. Хүзүүний сээрийн өвдөлтийн хамшигж
- Хүзүүний өвдөлт (цервикалги), хүзүү-гарын өвдөлт (цервикобрахиалги) хамшигж
 - Хүзүү-дагнаны өвдөлт (цервикокранионги)
 - Дал-бугалганы пориартроз
 - Хүзүүны шат хэлбарт булчингийн хамшигж
 - Сээр нурууны өвдөлт (торкалги)
2. Хүзүүний язгуурын дарагдлын хамшигж
- C5 ёзоорын хамшигж
 - C6 ёзоорын хамшигж
 - C7 ёзоорын хамшигж
 - C8 ёзоорын хамшигж
 - T1 ёзоорын хамшигж

Эмнэл зүйн хүчин зүйлээр:

- Нурууны хөдөлгөөнт бүтцийн мэдрэл-булчин, үе-холбоосны цочрол
- Нугасны язгуур мэдрүүлийн дарагдал

Эмнэл зүй:


Нурууны гарвалт нутгасны язгуурын өвдөлтийн хамшигж	Нутгасны язгуурын дарагдлын хамшигж
<ul style="list-style-type: none"> гэнэт янгинаж өвдөх хөдөлгөөн эрс хязгаарлагдах нурууны булчин чангараах булчингийн чангараалаас нуруу бегтийх, хазгай болох өвдөлт нуруунаас өгзөг, гуя, шилбэний гадна талзар дамжиж, янгинах шинжээр илрэх суудлын мэдрэл болон өгзөгний доод артерийг даражад бусалхий-суудлын өвдөлт илрэх явахад хел бадайрах, өвдөлт нэмэгдэх, доголох 	<ul style="list-style-type: none"> Хөдөлгөөний ачавалын үед нуруугаар хүчтэй өвдөх, суудлын мэдрэлийн дагуу дамжих Өвдөлттэй талдаа хөдөлгөөн хязгаарлагдах Нурууны булчингийн чантаралт үүсэх Нуруунд бегтер (кифоз), хажуу тал руу хазайлт (скалиоз) илрэх Язгуур татагдлын шинжүүд тод илрэх Бадайрах мэдрэхий буурах ёзоорын түвшинд рефлекс буурах буюу арилах ёзоорын түвшинд булчингийн гулыг гадагшлуулах, тавхай гэдийлгэх, тавхайг доош нугалах хүч супрах сул саа үүсэх
Хүзүү-сээрийн язгуурын өвдөлтийн хамшигж	Хүзүүний язгуурын дарагдлын хамшигж
<ul style="list-style-type: none"> хүчтэй гэнэт өвдөх толгой хүзүүний хөдөлгөөн эрс хязгаарлагдах булчин чангарч хүзүү муруйх өвдөлт дал, мөр, гар луу дамжих хүзүүний симпатик ширхэгүүд цочирсонос нуруу, хүзүүний артерийн судасны агчилт 	<ul style="list-style-type: none"> гэнэт хүзүүгээр нээвт хаттуулах толгойн хөдөлгөөн хязгаарлагдан хүзүүний булчин чангараах өвдөлт дал, мөр, гарсаа дамжих, гарын хуруу бадайрах ёзоорын түвшинд мэдрэхий буурах рефлекс супрах

<ul style="list-style-type: none"> • уусч лүгших, төвнэх өдөлт илрэх • дайрлага хэлбэрийн өдөлт хэдэн минутаар үргэлжилэх, • дал бугалын булчин хөвчирч чангарсантай холбоотой язгуурын бус өдөлт илрэх • булчингийн тэмтрэлтээр өдөлт нэмэгдэх • толгой эргэх, шуугих, огиудас хүрэх, нүд харанхуйлах, тэнцэврийн өөрчлөлтүүд илрэх • гаргт өвгөтөөвтэй-тэжээлийн өөрчлөлтүүд гарах (хавагнах, хөхрөх) 	<ul style="list-style-type: none"> • өзоорын түвшинд булчингийн гадапшуулах, нугалах, танийлгэх, холдуулах хүч буурах
Эмнэл зүйн явцаар нь:	
<ul style="list-style-type: none"> • дундажаар 1-2 долоо хоног 	<ul style="list-style-type: none"> • 2-3 долоо хоног үргэлжилэх, 1-1,5 сарын дараа засрал ёгне. • Архалжсан үед хэдэн сарвар, заримдаа дахилттай явагдаж, олон жилээр үргэлжилнэ.

Нурууны дегенератив өөрчлөлтэд (спондилоз, дискийн гулсалт) бүсэлхийн-ууцины хосаг зонхилж өртөгдөно.

Эмзэг жам

Ажлын удаан хугацааны нэгэн хэвшмэл
байрцалт, хөдөлгөөний ачаалал, доргион



Оношлогоо

Анамнез:

- ажил, мэргэжлийн онцлог
- тасралтгүй ахилласан хугацаа
- хөдөвлөмийн нахцэлийн тодорхойлолт
- ажлын байрны эрүүл ахуйн шинжилгээний дүгнэлтүүд
- өвчиний эхтэл, үргэлжилсэн хугацаа, суурь өвчин

Бодит үзлэгээр:

Нурууны гарвалт нугасны язгуурын өвдөлтийн хамжинж	Нугасны язгуурын дарагдлын хамжинж
Өвдөлтийн бүсэд: <ul style="list-style-type: none">мэдрэхүйн ворчлолт гарахгүйшермесний рефлекс алдагдахгүйбулчингийн саа уусэхгүй	Дарагдсан язгуурын бүсэд: <ul style="list-style-type: none">бадайрч өвднөмэдрэхүй буулнарефлекс арилнабулчин саажина
Шинжилгээнд:	
<ul style="list-style-type: none">Нурууны рентген зурагт бүсэлхийн нурууны спондилез, остеохондрозын шинж илрэн.	<ul style="list-style-type: none">Нурууны рентген зурагт бүсэлхийн нурууны спондилезын шинж илрэнНурууны бүсэлхийн-уучны хэсгийн КТ, МРТ(магнит резонанс томограф)-ийн шинжилгээнд дискийн ивэрхийн тодорхойлогдоно.

Ялган оношлогоо

- Хархийн артрит
- Сүрьеэгийн слонгиллит
- Нугасны хавдар
- Нурууны ясны хавдар
- Нугаламын хугарал
- Нурууны теролхийн гажиг
- Нугас, захын мэдрэлийн хатингаршил
- Булчингийн даамжрах хатингаршил
- Цочмог урзвасын полирадикулоневропати
- Миастени
- Теролхийн ул даамжрах миопати

Хүндрэлт

- Нурууны нугаламын гулсалт
- Булчингийн хатингаршил

Эмчилгээ

	Эмчилгээний төрөл
--	-------------------

I.	Дэглэм: <ul style="list-style-type: none"> • Ажлын нехцлийг солих • Хүнд юм өргөхгүй, норохгүй, даарч хөрөхгүй байх • Тохирсон дасгал хөдөлгөөн хийж байх
II.	Эмийн эмчилгээ: <ul style="list-style-type: none"> • Өвчин намдаах • Стериодын бус үзвэслийн эмчилгээ • Булчингийн алшилт бууруулах • Эмийн хориг тавих (өвдөлт сэдрээх цагуудад) • Амин дэмийн эмчилгээ • Хүнд явцтай үед кортикостероид эмчилгээ
III.	Эмийн бус эмчилгээ: <ul style="list-style-type: none"> • Нехен саргээх, физик, биеийн тамир эмчилгээ • Раашан, шавар, татлага, зүү тохиур эмчилгээ • Мэс заслын эмчилгээ

Үрьдчилан сэргийлэлт

- Үйлдвэрийн техникийн агуулгүй ажиллагаа, зруул ахуйн дэглэмийг мордох
- Дахин давтагдах хөдөлгөөнийг аль болох багасгах (механиксуулах, багаж томог төхөөрөмжийг өөрчлөх, ажлын байрыг солгож ажиллуулах, ажлын байрыг орлогтох, багаар ажиллуулах)
- Ажилд анх аваажад зруул мэндийн үрьдчилсан үзлэгт оруулж, зондц нэг удаа мадрэл, мэс заслын эмчийн үзлэгт хамруулах
- Ажилгчид ажил, амралтын дэглэмийг сахих, ажлын дундуур завсарлаж, лимнастик, вортко иллэг хийх
- Ажиллагчдын биеийн эсэргүүцлийг сайжруулах, витаминжуулах, сувиланд амруулах
- Биеийн жин нэмэгдүүлэхгүй байх

Хөдөлмөр зохицуулалт

- 1-2 сар эмнэлгийн хуудсаар эмнэлэг-сувиллын эмчилгээ хийх болон түр хутацаагаар ажлын нехцлийг солино.
- Хөдөлгөөн эрс хязгаарлагдсан үед ажлын нохцлийг бүрмөсөн сольж, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтооно.

2.2 МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН МЭС ЗАСЛЫН ӨВЧНҮҮД

2.2.1 МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ХӨЛИЙН ХӨХ СУДАС ӨРГӨСӨХ ӨВЧИН

Тодорхойлолт

Ажлын байранд удаан хугацаагаар явах, зогсох, бивийн хүчний ачаалал бүхий ног хэвийн албадмал байрлалд ажиллах зэргээс доод мөчний шийний судасны дотор талд байрлах хавхлагын болон ханын уян чанар алдагдсанас шийний судсууд өргөсөх тэлзгдах зангиж будуурэх эмгэг уусэхийг мэргэжлийн шалтгаант хөлийн хөх судасны өргөсөх өвчин гэнэ.

Үйлдвэрлэлийн салбар, ажил мэргэжил, нөлөөлөх хүчин зүйлс


Үйлдвэрлэлийн салбар	Ажил, мэргэжил	Нөлөөлөх хүчин зүйл
<ul style="list-style-type: none">• Уул уурхайн үйлдвэрлэл• Барилгын салбар• Хивсний үйлдвэр• Худалдаа, нийтийн ахуй үйлчилгээний салбарууд• Соёл шинжлэх ухааны салбарууд• Эмнэлгийн салбар г.м.	<ul style="list-style-type: none">• уурхайчин• малтагч• времдэгч• суурь машинч• геологич• барилгачин• ачигч• зөвлөч• худалдаач• үочин• тогооч• буюгчин, балетчин• нэхмэлчин• сүлжигч• зэрэгч• овдопчин• мэс засалч, мэс заслын сувилаач г.м	<ul style="list-style-type: none">• байглын зогсоо нөхцлийн ажил• хүнд ачаа байнаа өргөж зөвхөн ажил• хөлийн хүч их хэмжээгээр шаардсан ажил• удаан хугацаагаар хол газар явган явах нас, хуйс• хот таргалалт• сахарын диабет• байнга гармоны зм балдмал хэрэглэдэг хүмүүс г.м

Ангилал

Хэлбэрээр нь:	Явцаар нь:
<ul style="list-style-type: none">• Бортон хэлбэр• Тахир хэлбэр• Хуудийлсэн хэлбэр• Холимог хэлбэр	<ul style="list-style-type: none">• Энглэшийн үе• Энглэшил алдагдах үе• Хунцрулийн үе

Эмзэг жам

- Хөлийн хөх судасны өргөсөх эмзгийн үндэс нь хөх судасны цусны рефлюкс юм.



Схем 1. Хөлийн хөх судсаар цус урсах хэвийн механизмын схема

Схем 2. Хөлийн хөх судсаар цус урсах зүйгэг механизмын схема

- Булчын жигд агахад хөх судасны тонус ихсэж, хавлага нээгдэн хөх судсаар цус дээш шакагдана (схем 1, схем 2А)
- Булчын удаан хугацаанд хедэлгээнгүй болоход хөх судасны тонус буурч, хавлага дутуу хаагдан цус буцаж урсан (схем 2В).
- Супарсан хавллагаар буцаж орж ирсэн цус судасны хананд дараалт үзүүлж, судасны хана гадагш цүлхийнэ. (схем 2С).

Эмнэл зүй

Энэгшилийн ўе:

- удаан зогсоход хөл чилж, овдох
- ажлаас буусны дараа хөл хавагнах
- шенёдөв чинэрэн зовиурлах
- ослое хавдар буух

Энэгшил алдагдах ўе:

- удаан явахад хөл цуцаж, ядрах
- онгац хөх судас өргөсөх
- зангилаа үүсэх
- өргөссөн судас арьсав дотроос нь түлхэн, тэр хавийн тэмээлийг алдагдуулах учир арьс нимгэрч эхэндээ хөхөлбөр байснаа ажум хүрэнтэн, шархлах
- шилбэ тавхайгаар ажлын болон ачааллын дараа хавагнах
- шилбээр загатнах

Хүндрэлийн ўе:

- дээрх зогсоодуудаас гадна тэмээлийн дутагдалд орж, шархлах
- улмаар судас бөглөрч, байнгын хавантай байх /хаван оройдоо ихсэж өгнөөдөв буурч яваандaa шагай шилбэний доод хэсгээр арьс хүрэнтэж нессөжжих/
- тэмтрэхэд судасны өргөссөн хасаг зөвлөн бүхэлзэж зарим хэсгийн нэж тромбо тэмтрэгдэх
- овчтонг зогсоод судасны дүүрэлт бүдүүрэл ихсэж, хэвтэхэд багасах

Хундрэл

- Тромбофлебит
- Тэмээл хямралын яршил
- Өргөссөн хөх судас хагарч цус алдах аюултай

Оношлогоо

I.	1. Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийн үнэлгээ, хэмжилтийн дүгнэлт
II.	Зовиур
III.	Бодит үзлэг
IV.	Эмнэл зүйн шинж тэмдэг
V.	Лабораторийн шинжилгээ: ЦЕШ, Коагулограмма
VI.	<p>Судасны өргөслийг тодорхойлдог сорилтууд (Тлонюэс-Трендленбургийн сорил, Гаккен-брүхийн сорил, Пратта-2 сорил, Шейницийн турван чангалаа сорил)</p> <ul style="list-style-type: none"> • Тронюэс-Трендленбургийн сорил: - Sapheno-femoral салаалалтын түвшинд венийн судасны хавхлага хэвийн зохицлаж байвал өвчтөнгөх хэвтүүлээд хелийг өргөхөд венийн судасны дуурэлт намдана. - Sapheno-femoral салаалалтын түвшинд 2 хуруугаар дарсан чигээр босгоно. Дараахаа зогсооход өргөссөн судас цусаар дүүрч байвал өвчтөнд sapheno-femoral салаалалтын түвшинд хавхлагын дутал байнга гэм узно. - Судас дууряахгүй бол хавхлагын дутал түүнээс доош байрлаж байгаа нотолно <ul style="list-style-type: none"> • Гаккенбрүхийн сорил: - Өвчтнийг зогсоож байгавд өргөссөн судасны зангилаан дээр гарваар дарна. Ханиалгуулахад хавхлагын дутагдлын уед гаргасан цусны түүхэлт мэдрэгдэнэ. • Пратт II сорил: - Хэвтүүтээд өнгөц вен хоосорсны дараа шилбэнээс гуяны доод 1/3 хүртэл уян бинтээр ороно. Өвчтнийг босгоно. Үүнээс 5-6 см дээр 2 дахь уян бинтээр ороно. Эхний уян бинтэйгүй суппахтай зэрэг 2 дахийг ороодог. Холбогч венийн хавхлагын дутагдалтай уед эхний бинтэйгээ тайлангаат венийн судас цүлхийг гарч ирнэ. • Дельбо-Пертесийн сорил: - Зогсоож байгаад гуянд чангалаа тавиад байранд нь 30 секунд алхуулна. Гүний вен чөлөөтэй уед чинарч өргөссөн өнгөц венийн судасны зангилаа, чинэрэлт басасна, зөвлөл арилна.
VII.	<p>Хэт авиан шинжилгээ</p> <ul style="list-style-type: none"> - Хелийн судасны хэт авианы допплерт шинжилгээ Өргөссөн венийн дагуу датчийг гүйлгэхэд хавхлагын дутагдтай хэсэгт цусны ургалт мэдрэгдэнэ - Хелийн судасны хэт авианы дуплекс шинжилгээ Венийн хавхлагын дутал, ихавчлэн sapheno-femoral венийн салаваны өргөсөл, холбогч венийн дутал, хүндэрэлийн уед булзант бөглерийн шигокууд - венийн хавхлагын дутмагшил, цусны ургалын удаашрал зогсонгишлээс хамааран үүссэн бутон, судасны хана үрэвссэн харагддаг Доплерографийн шинжилгээ - Гуяны арын хөх судасны хавхлагын дутагдал тодорхойлждана

	Дуплексийн шинжилгээ
	<ul style="list-style-type: none"> - Хөх судасны диаметр, судасны хана, хавхлагын аппаратын өөрчлөлт тодорхойлгдано.

Эмчилгээ

Эмчилгээний төрөл	Бүлэг
Дэглэм	<ul style="list-style-type: none"> • Оройд хөөр хөлөө дэрэн дээр тавьж унтах • Зориулалтын резинэн оймс даруулга хэрэглэх • Зогсоо хийх ажлаас зайлсхийх • Ажлын завсар зайгаар цаг тутам хөлөө амрааж байх • Биеийн жин хасах • Хоолны дэглэм
Эмийн	<p>Цусны бичил эргэлтийг сайжруулах Судасны ханыг болжуулах Бүлэгнэлтийн эсрэг эмчилгээ</p> <p>Тарилга эмчилгээ</p> <ul style="list-style-type: none"> • хэт авианы хяналтын дор этаноламиин тарьсны дараа бүлэгт бөглөрлөвсөн сэргийлж, хэдэн дооюу хоногийн түрүү даралттай болот хийно. (Өдөргөөс доошихи судас өргөссөн үед хатууруулах тарилга эмчилгээний үр дүн илүү байна)
Эмийн бус	<p>Мэс заслын эмчилгээ:</p> <ul style="list-style-type: none"> • Тројнов-Трендленбургийн мэс засал-цавинаас эзэнтүүлж булчингийн дээд хасаг хүргэлх венцийн судсыг авна. • Мэс заслын дараа хөглийг нь биттуу чанга боож, 24 цагийн турш дээш өргөссөн байдагд байлгана.

Урьдчилан сэргийлэлт

- Ямар ч тохиолдолд зогсоо ажлын цагийг зохицуулах
- Ажиллагаадад 1-2 цаг тутамд 10-15 минут завсарлага авч, дээш харж хэвтэн 2 хөлөө өргөж, буулгах дасгал хийх, ажиллахдаа зориулалтын оймсоо омох
- Үйлдвэрлэлийн гимнастик тогтолцох хийх, алхаж байх, хөлийн иллог хийх (булчинийн ажиллагаа, цусны эргэлтийг сайжруулах)
- Судас өргөвөх магадлалтай хэсгийн булчинг чангруулах дасгал зөв сонгож хийх
- Байнга судаг ажилтай бол уе босч биеийн чигээг гаргаж байх
- Хөлийг өндөрлөж амрааж байна.
- Зориулалтын уян оймс, трико вимсэж ажиллана.
- Зогсоо ажиллахаас аль болохоор зайлсхийж, өндөр сандал дээр сууж ажиллана.
- Биеийн жин бууруулна.

Анх ажилд орох хүмүүсийг эмчилгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах Ажиллагаадын хугацаат эрүүл мэндийн үзлэгт журмын дагуу хамруулах

Хөдөлмөр зохицуулалт

Өвчний илрэпийн зэрэг, өвчний хундрэл, хөдөлмөрийн эрүүл ахуйн нехцэл, тасралтгүй ажилласан жил, мэргжлийг харгалзсан үзэж, ажлын байрнаас түр болон бур мөсөн чөлөөлж, хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг зохих заалтын дагуу тогтоосно.

2.2.3. МЭРГЭЖЛЭС ШАЛТГААЛСАН АРТЕРИЙН СУДАСНЫ БӨГЛӨРӨЛТ ҮРЭВСЭЛ

Төдөрхойлолт

Үйлдвэрлэлийн явцад ажлын байран дахь бага хэмтэй нохцелд удаан хугацаагаар ажилласнаас доод мочний arterийн судасны хананд өөрчлөлт гарч нарийсан, булан үүсч, судасны хандий бөглөрсөөр цус үрсахгүй болж улмаар ухжил үүсөх эмгэгийг мэргэжлэс шалтгаалсан arterийн судасны бөглөрөлт үрэвсэл гэн.


Үйлдвэрлэлийн салбарууд, ажил мэргэжил, нэвтрэлх хүчин зүйлс

Үйлдвэрлэлийн салбарууд	Ажил, мэргэжил	Нэвтрэлх хүчин зүйл
<ul style="list-style-type: none"> загасны үйлдвэрийн зам гүүрийн салбар зоорь, хөргөгч, хөргөлтийн системтэй салбарууд геологийн хайгуулын салбар мах боловсруулах үйлдвэр ой модны аж ахуйнүүд хивс, нахмалийн үйлдвэрүүд гүний уул уурхайн үйлдвэрлэл г.м 	<ul style="list-style-type: none"> загасчид гүүр баригч геологич оид мод бэлтгэгчид хөргөгч, хөргөлтийн системтэй зооринд ажиллагсад усан сангийн ажилчид нахмалчин, утас ороогч, зэрэгч г.м 	<ul style="list-style-type: none"> хэт хүйтэн байнгын ус, чийгтэй нохцел ижэвчлан 25-40 наасны эргтэйчүүдэд тохиолдоно биеийн жин (хэт туранхай) тамхи, архи согтууруулах үндэвчлийн хэрэлзээ

Ангилал

- Судасны нарийсалтын үе - Судасны мэдрэлжүүлэлтийн үйл ажиллагааны өөрчлөлт орж судас нарийсаж эхлэн
- Судас нарийсаж бөглөрөх үе - Судасны нарийсалттай удаан хугацаанд байнаас болоод интимуудийн ургалт явагдаж судасны бөглөрөл болж эхлэн
- Ухжилийн үе - Шархлаа үүсч улмаар зийн гүн тэжээлийн дутагдалд орсноор ухжинэ
- Хийт ухжилийн үе - Энэ үед хуурай ба нойтон ухжил явагдана

Эмгэг жам



Архаг удаан явцтай


- хөлийн эрээн булчингаар чинэрч овдех
- гүя шилбээр янгинаж овдех
- хөлийн хэлбэр алдагдаж (өвдөлтөөс болж улны гадна хэсэгт ачаалал ихтэй яснаас хөл гадагш майга лишгэгдэнэ)
- хөлийн тавхайд зэр ургах
- хол амархан эцэж цуцах
- хөлийн эрээн булчин татах
- тавхай, цимбэний арьс хөхрөх
- хол хавагнах
- осгийд яс ургах
(ахиллын шормосний бахлагдэх хэсэгт дэгээ ба шөвөг халбэрийн яс ургана)

Халийн тавхайн хавтгайрах явчин нь заримдаа хөлийн хурууны ясны артроз ба судасны өргөсөх өвчинтэй хавсарч тохиогдох явдал энбэг байдаг.

Оношлогоо

1. Ажлын байрны эрүүл ахуйн нехцелмийн үнэлгээ, хэмжилтийн дүүцнэ
2. Зониур
3. Бодит үзлэг
4. Эмнэл зүйн цинж тэмдэг
5. Хөлийн тавхайн ясны рентген зурагт
 - нумын онц $g 103^{\circ}$ -аас дээш
(хөлийн тавхайн холбогч шармаснууд супарсанас)
 - ясны үргалт тодорхойлгож болох
6. Биохимиийн шинжилгээнд: цусанд кальци, фосфор багассах

Схем 3. Рентген зураг дээр хийх тавхайн онцг хэмжилтийн загвар



Ялган оношлогоо

1. Гэмтлийн гаралтай хавтгай тавхай
2. Төрөлхийн хавтгай тавхай

Урьдчилан сэргийлэлт

Эх үүсгэвэрт чиглэсэн арга хэмжээ :

- Ажлын байранд хэрглэгдэх багаж, тоног төхөөрөмжийг зөв тохиромжтой байрлуулаж, ажиллагсдад ажиллахад хамгийн хялбар, ачаалал, хүндэтгүй байхаар ажлын байрны нөхцөлийг хангасан байх
- Ажлын байрны байрлалыг тодорхой хугацаатайгаар сольж байх
- Үйлдвэрлэлд автомат ажиллагааг нэвтрүүлох
- Ажлын дундуур 5-10 минут холийн дасгал тогтолцох

Хувь хүнд чиглэсэн арга хэмжээ:

- Усан спорт, дугуй эзргээр хичээллэж холийн дасгалыг байнга хийх
- Зориулалтын улавч, гутлыг байнга хэрглэх

Анх ажилд орох хүмүүсийг эмнэлгийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулах
Ажиллагаодыг хугацаат зруул мэндийн үзлэгт журмын дагуу хамруулах

Хөдөлмөр зохицуулалт

- Овчний эхний үед ажлын хортой нэлвэллэвс чалвелж, ажлын нөхцөл солино.
- Дараагийн үеүдэд эмнэл зүйн байдлаас хамааран, ходолморийн чадвар алдалтыг тогтоондо.

2.2.3. МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН АРТЕРИЙН СУДАСНЫ БӨГЛӨРӨЛТ ҮРЭВСЭЛ

Тодорхойлолт

Үйлдвэрлэлийн явцад ажлын байран дахь бага хэмтэй нохцолд удаан хугацаагаар шиллгаснаас доод мечний arterийн судасны хананд өөрчлөлт гарч нарийсан, бүлэн үүсч судасны хөндий болгарсан тохиолдоо тус үрсахгүй болж улмаар үхжил үүсэх эмгэгийг мэргэжлээс шалтгаалсан arterийн судасны бөглөрөлт үрэвслэл гэна.


Үйлдвэрлэлийн салбарууд, ажил мэргэжил, нөлөөлөх хүчин зүйлс

Үйлдвэрлэлийн салбарууд	Ажил, мэргэжил	Нөлөөлөх хүчин зүйл
<ul style="list-style-type: none"> загасны үйлдвэрлийн зам түүрийн салбар зоорч, харгач, хергелтийн системтэй салбарууд геологи хайгуулын салбар мах боловсруулах үйлдвэр ой модны аж ахуйнууд хивс, нахмэлийн үйлдвэрүүд гүний уул уурхайн үйлдвэрлэлт г.м. 	<ul style="list-style-type: none"> загасчид гүүр баригч геологич ойд мод бэлтгэгчид хергач, хергелтийн системтэй зооринд ажиллагсад усан сангийн ажилчид нахмалчин, утас ороогч, азэрэгч г. м 	<ul style="list-style-type: none"> хэт хүйтэн байнгын ус, чийгтэй некцел ижэвчлэн 25-40 насны эрэгтэйчүүдэд тохиолдоно биеийн жин (хэт туронхай) тамхи, архи согтууруулах ундаануудын хэрэглээ

Ангилал

- Судасны нарийсалтын үе - Судасны мэдрэгжүүлэлтийн үйл ажиллагданы өөрчлөлт орж судас нарийсаж эхлэн
- Судас нарийсч бөглөрөх үе - Судасны нарийсалттай удаан хугацаанд байснаас болоод интимуудийн ургалт явагдаж судасны бөглөрөлт болж эхлэн
- Үхжилийн үе - Шархлаа үүсч улмаар эдийн гүн тэжээлийн дутагдалд орсноор үхжинэ
- Хийт үхжилийн үе - Энэ үед хуурай ба нойтон үхжил явагдана

Эмгэг жам



Хүйтэн нохцолд удаан ажилласнаас болж судасны хана эхлээд агшиж, гэмтэн дараа нь интимүүдийн ургалт болоноор судасны хана зузааран бөглөрч, неж тогтох, цусан хангамж өөрчлөгддөж, судас нарийсдаг.

Эмнэл зүй

Өвчиний явц булзенгийн байрпал, тархалт, үүссэн хутацаа, салсаа судасны хангамж зэргээс хамаарна.

1. Судас нарийслын үе

- хелийн шилбэ гүя чинэрч өвдөх
- тавхай, шилбэ, гүя нийтдээ хавагнах
- тавхайт хөдөлгөхөд шилбэний эрээн булчин хүчтэй чинэрч өвдөх / Хомонцайн шинж/
- хелийн шилбэ гадна хэсэгт өнгөц байрлалтай бадайрч, мэдрэхүй бегасах
- шагай өвдөгний үеэр хөших
- эрээн булчин хандуурлох
- шөрмөс татах
- явакад хел супрах амархан ядрах
- хел даарах шинж эрт илрэх
- 500-1000 м зайд явакад хелийн эрээн булчингаар чинэрч базалж өвдөх

2. Судас нарийсан бөглөрөх үе

- дээрх шинж тэмдгүүд хөвээр ургалжлэн тод багеед тогтмол болох
- цусан хангамжийн дутпаас болж хелийн эрээн булчингаар өвдөх
- тавхай, шилбэний судасны лутшилт супрах
- хел догоюу
- өвдөлт явах үед илрэх (250-500 м яванд өвдөлт илэрнэ)
- амарч байгаад дахин явдаг болох

3. Үхжиллийн үе

- хелийн өвдөлт эрчимжийг ойрхон зайд илрэх (50-250 м зайд)
- тайван байхад болон шене өвдох
- булчин хатингарших
- хелийн арьс хуурайших
- хумсны хэлбэр алдагдан зузаарах
- шилбэний үс унах
- өвдсэн талын хел даарах
- хел бадайрч өвдөх нь тогтмол болж явган явакад, тайван байхад ч өвдөх
- хелийн хуруунуудын арьс бор хүрэн болж тэр хэсэгтээ арьсны гадарга дээр цэврүүтэж эхлэх
- цвацдаа шархалж ярших

4. Хийт үхжиллийн үе

- хелийн хуруу тавхайн хэсгүүдэд хуурай болон нойтон хэлбэрийн үхийн үүснэ
- өвдөлт тэсвэрлэхэд хэцүү болох
- тавхай хурууны үзүүр үхжих
- том артерийн лутшилт тэмтрэгдохгүй болох

Хүндэрэл

- Тэжээл хямралын яршил
- Доод мөчний үхийн (гангрена)
- Тромбозмболи

Оношлогоо

1. Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийн үнэлгээ, хэмжилтийн дүгнэлт
2. Зониур
3. Бодит үзлэг
4. Коагулограмма
5. Багажийн шинокилгээ:
 - Хэт азиан допплерографи
 - Реовазографи
 - Капиллярграфи
 - Артерийн ангиографи

Эмчилгээ:

I.	<ul style="list-style-type: none"> • Хэнтрийн дэслэм • Мачийг уян бинтээр ороох • Хелийг хеделгээнгүй байлгах, шохойн аравч тавих • Хелийг өргөх ондерлэх • Архи, тамхины хэрэгтээг зогсоох
II.	<ul style="list-style-type: none"> • Өвдөлт намдаах
III.	<ul style="list-style-type: none"> • Бодисын солилцоог идэвжүүлах
IV.	Цусны ургал сайжруулах, цус шингэлах, булагнзатийн эсрэг
V.	<ul style="list-style-type: none"> • Харшлын зорг эмчилгээ
VI.	<ul style="list-style-type: none"> • Тайвшруулах эмчилгээ
VII.	<ul style="list-style-type: none"> • Атеросклерозийн эмчилгээ
VIII.	<ul style="list-style-type: none"> • Антибиотик эмчилгээ хийх
IX.	<ul style="list-style-type: none"> • Цус цэвэршуулэх эмчилгээ Плазмоферез
X.	<ul style="list-style-type: none"> • Физик эмчилгээний аргууд <ul style="list-style-type: none"> - Хүхэрт устремчийн ваннад оруулах - Дулааны ба гарлийн эмчилгээ - Раshawan сувилал
XI.	<ul style="list-style-type: none"> • III, IV эзэргийн үед мэс заслын эмчилгээ хийх

Урьдчилан сэргийлэлт

Эхүүсгэвэрт чиглэсэн арга хэмжээ

- Зориулалтын дулаан хувцас, хэрэгслэлээр хангах
- Ажиллах 2 цаг тутамд халуун хоол, цай, өгөх
- Ажлын үед 2 цаг тутамд дулаан байранд 5-10 минут амраах

Хувь хүнд чиглэсэн арга хэмжээ:

- Халуун бигнүүр тогтмол хэрэглэх
- Хүйтнээс хамгаалдаг зориулалтын хувцас, гутлыг тогтмол хэрэглэх
- Эрүүл ахуйн дэслэмийг чанд мөрдөж ажиллах

- Аял ажилд орох хүмүүсийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах
- Ажиллагсдыг хугацаат эрүүл мэндийн үзлэгт журмын дагуу хамруулах

Хөдөлмөр зохицуулалт

- Өвчний зоний үед ажлын хортой нэлвэвлээс чалеёлж, ажлын нэхцэл солино.
- Дараагийн үеүдэд эмнэл зүйн байдлавас хамааран, хөдөлмөрийн чадлыг тогтооно

2.3. Нүдний өвчнүүд

2.3.1. МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН БОЛОРЫН БҮДЭГШИЛ (КАТАРАКТ)

Хүлдээрлэлийн явц, ажлын байрнаас ууссан халуун болон хортой түяа, химийн бодисын нөлөөллиөс болор бүдэгших эмгэгийг хална.	
<ul style="list-style-type: none"> • Хэт халуун байх - ондар хэмтэй орчинд ажиллах • Хортой түяаны нөлөөнд ажиллах (нам улаан түяа, радио долгион, микродолгион, о. В. түяа, лазер түяа, рентген түяа, хэт ягаан түяа г.м.) • Химийн бодистой ажиллах (тринитротолуол, бензол, хар тугалга г.м.) • Харанхуйд ажиллах 	

Үйлдвэрлэлийн салбар, ажил мэргэжил, нөлөөлөх хүчин зүйл

Үйлдвэрлэлийн салбар	Мэргэжил	Нөлөөлөх хүчин зүйл
<ul style="list-style-type: none"> • Уул уурхайн салбар • Дулааны цахилгаан станц • Хивсний үйлдвэр • Төмөрлөг боловсруулах үйлдээр • Баяжуулах үйлдвэр • Эмнэлгийн салбар • Химийн салбар 	<p>Лаборант, химийн цэвэрзэгээний ажилчид зэрэг химийн бодистой ажилладаг бүх мэргэжлийн хүмүүс, рентгэн түяатай ажилладаг рентгений эмч, технич, хэт улаан, хех, ягаан түяатай ажилладаг физик, эмчилгээний эмч, сувилагч, түяаны эмч, металл хайллагч, галч, хайлтуулах зуухчин, цуттуурчин, элс хатаагч, металл цувигч, эрчим хүний 35 атм ба түүкээс дээш дараалтаар ажилладаг зуухны машинч, зуухны цахилгаан ба хийн ганнуурчин, зуух үзүүлэгч зэрэг</p>	<ul style="list-style-type: none"> • Ажлын байрны орчны хэм хэт ондар байх • Хортой түяа, химийн бодисын нөлөөнд удаан хугацаагаар ажиллах • Зөвшөөрөгдхөх хэмжээнээс бага гэрэлтүүлэгтэй орчинд удаан хугацаагаар ажиллах г.м.

Ангилал

Хамралтаар нь	<ul style="list-style-type: none"> • Нэг нүдний • Хоёр нүдний
Үе шатаар нь	<ul style="list-style-type: none"> • Эхлэл үе • Гүйцэт боловсроогүй үе • Боловсорсон үе • Хэт боловсорсон үе
Шалтгаанаар нь	<ul style="list-style-type: none"> • Хордлогын катаркт • Түяаны нөлөөллиөс ууссан катаркт

Эмнэл зүй

- Хараа муудах
- Төвийн хараа мэдэгдэхүйц муудах
- Юм харахад манантаж, сааралтаж харгдах

Оношлогоо

Үе шат	Зовиур	Шинжилгэээр гарах вероят
1. Эхлэх үе	Нүдэн дотор утас хялгас хөөхөх, гэрэлтүүлэгч зүйлийг харахад цацарч харгдах, холын хараа муудах	<ul style="list-style-type: none"> - Хажуутийн гэрэлтүүлгээр онцын өөрчлөлт ажиглагдажгүй Нэвтрхий гэрэлтүүлэгээр хүүхэн хараа дотор хэсгчилсэн будэгшил харгдана. - Б-микроскопид, Болорын ширхэгүүд задарч, усан зангар зайд үснэ.
2. Гүйцэд боловсроогүй үе	Төвийн хараа мэдэгдэхүйц муудсан	<ul style="list-style-type: none"> - Хажуутийн гэрэлтүүлгээр, Болор саарал өнгөтэй болсон солонгон бүрхүүлийн сүүдэр болор дээр тусна Нэвтрхий гэрэлтүүлэгээр, Нүдний өроолын рефлекс супарсан. - Б-микроскопид, усан зангар зайд улам их болсон дөгритээр дуурсан
3. Боловсорсон	Биет дүрс харахгүй ба гэрэл мэдэрнэ.	<ul style="list-style-type: none"> - Хажуутийн гэрэлтүүлэгээр Болор жигд саарал өнгөтэй болсон солонгон бүрхүүлийн сүүдэр болор дээр тусахгүй. - Нэйт гэрэлтүүлэгээр Нүдний өроолын рефлекс угүй болсон. - Б-микроскопид, Болорын зүслэгт бүрэн будагшил үснэ.
4. Хэт боловсорсон	Хараа бага зэрэг саргана	<ul style="list-style-type: none"> - Хажуутийн гэрэлтүүлэгээр Солонгон бүрхүүл чичирхийгээ. - Нэвтрхий гэрэлтүүлэгээр Нүдний өроолын рефлекс үүсэхийн зэрэгцээ доод хэгээр уутанд унасан цом харгдана. - Б-микроскопид, Болорын ар урд уутны зүслэгт л байна.

Ялган оношлогоо

- Бусад шалтгаант болорын будэгшил (насны, гэмтлийн, дотоод змэгт г.м.)
- Шилзэнцэрийн будэгшил (помутнение роговицы)
- Арын сегментийн змэгт

Шинжилгээ

- Биомикроскопи (хажуутийн болон нэйт гэрэлтүүлэгээр)
- A, B scan-аар болорын будэгшилийг тодорхойлох

Хүндэрэл

Нүдний дотоод дараалт ихдэх хурц хэлбэрийн глаукомын шинж илэрнэ.

Эмчилгээ

Болорын бүдэгшил үүсгэж буй шалтгааныг арилгана. Үндсэн эмчилгээ нь бүдэгшил болорыг авч хиймэл болор тавих мэс засал.

Урьдчилан сэргийлэлт

Ажил, мэргжилтэй холбоотой болорын бүдэгшилээс урьдчилан сэргийлэхдээ шуулгүйн дурмийг чанд сахин, ажлын нехцэлийн зруул ахуйн зөвшиоорогдех дээд замжээг хатуу баримтлах, зруул ахуйн бух талын нехцэлийг бурдуулэх нь чухал юм. Хувийн хамгаалах хэрэгслэ болох халтууны болон түянаас хамгаалсан нүдний шил (түяаны, тоосны) зүүж ажиллах ёстой.

Хөдөлмөр зохицуулалт

Өвчиний илрэлийн зэрэг, өвчний хүндэрэл, хөдөлмөрийн зруул ахуйн нехшэл, гасралтгүй ажилласан жил, мэргжлийг харгалзан үзэж, ажлын байрнаас түр болон бур месөн чөлөөгэх, хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг зохих завалтын дагуу тогтооно.

2.3.2. МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН НУДНИЙ ДОТООД ДАРАЛТ ИХСЭЛТ

Төслийн төвийн төслийн төсөл

Үйлдвэрлэгийн явц ажлын байрнаас үссэн химийн хортой бодис болон халуун, төрөл бүрийн цацраг идэвхт түяаны налеевлвес болж нудний дотоод даралт хзвийн хэмжээнээс номэгдсэнээс харааны мэдрэлд налеөлж, харааны үйл алдагдан, нудний ёроогц овормоц өөрчлөлт үүсдэг өвчинг нудний дотоод даралт ихсэх эмгэг гэнэ.

Нийтийн төслийн төсөл

- Химийн хортой бодис
- Өндөр кэм
- Цацраг идэвхт түяаны налеевлэлд ажиллах

Үйлдвэрлэлийн салбар, ажил мэргэжил, нолохлох хүчин зүйл

Үйлдвэрлэгийн салбар	Мэргэжил	Нолохлох хүчин зүйл
